



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Ус цаг уурын орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СБА-2022/19/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баруун-Урт
2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 99029193

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 99035990

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Захирал: А.Сарангэрэл

Утас: 9988 4842

Цахим хаяг: gereltekhburtgelaudit03@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт.....	19
4.3 Албан шаардлага	19
4.4 Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Suikbaatar@audit.gov.mn

ᠰᠡ᠋᠋᠋᠋ ᠠ᠋᠋᠋᠋ № 43

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН УС ЦАГ УУР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА Х.ЭНХБАЯР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>51,362,764.16</u>	<u>38,351,094.86</u>
33	АВЛАГА	1,461,422.00	-
335	Бусад авлага	1,461,422.00	-
3351	Байгууллагаас авах авлага	1,461,422.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	49,901,342.16	38,351,094.86
351	Түүхий эд материал	37,668,959.17	25,766,011.87
35110	Тусгай зориулалттай материал	37,668,959.17	25,766,011.87
354	Хангамжийн материал	11,847,382.99	12,189,082.99
35410	Бичиг хэргийн материал	409,740.00	409,740.00
35420	Аж ахуйн материал	4,832,966.67	5,174,666.67
35460	Сэлбэг хэрэгсэл	6,604,676.32	6,604,676.32
35600	Мал амьтад	385,000.00	396,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>361,964,764.52</u>	<u>401,730,085.63</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	361,964,764.52	401,730,085.63
392	Биет хөрөнгө	315,040,764.52	354,073,725.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	142,748,607.66	152,722,061.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	(47,596,043.36)	(50,739,832.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	437,407,573.78	437,407,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(383,408,964.48)	(393,270,893.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	349,740,691.30	275,591,256.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(199,095,412.78)	(82,517,267.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,693,797.00	8,931,858.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,682,067.45)	(5,800,748.30)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,498,868.97	15,498,868.97
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,266,286.12)	(3,749,152.16)
393	Биет бус хөрөнгө	46,924,000.00	47,656,360.00
39301	Програм хангамж	1,391,200.00	732,360.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,391,200.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	46,924,000.00	46,924,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>413,327,528.68</u>	<u>440,081,180.49</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>413,327,528.68</u>	<u>440,081,180.49</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	413,327,528.68	440,081,180.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	627,273,463.60	627,273,463.60
51101	Өмч: - төрийн	627,273,463.60	627,273,463.60
512	Хуримтлагдсан үр дүн	(257,841,720.50)	(231,088,068.69)
51210	Өмнөх үеийн үр дүн	(257,841,720.50)	(257,841,720.50)
51220	Тайлант үеийн үр дүн		26,753,651.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	43,895,785.58	43,895,785.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>413,327,528.68</u>	<u>440,081,180.49</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,102,548,010.07	938,630,816.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	216,782,622.07	97,757,197.99

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120	Нийтлэг татварын бус орлого	216,782,622.07	97,757,197.99
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	216,782,622.07	76,474,856.04
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	100,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	216,682,622.07	66,783,999.79
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгө	-	9,590,856.25
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал	-	21,282,341.95
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	885,765,388.00	840,873,618.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	817,820,000.00	823,662,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	816,501,100.00	823,662,000.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	1,318,900.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,904,588.00	17,211,618.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,524,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	15,089,706.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,904,588.00	597,312.50
1330	Төсвийн захирагчдаас	66,040,800.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	66,040,800.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	951,994,351.23	911,877,164.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	951,994,351.23	911,877,164.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	867,024,469.01	886,325,048.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	676,708,371.78	682,221,032.59
210101	Үндсэн цалин	481,531,023.43	462,273,737.82
210102	Нэмэгдэл	165,232,659.97	196,090,465.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,944,688.38	23,856,829.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,598,166.00	88,196,280.58
210201	Тэтгэврийн даатгал	60,740,937.00	62,865,588.31
210202	Тэтгэмжийн даатгал	6,793,058.00	6,220,408.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,424,365.00	5,453,841.84
210204	Ажилгүйдлийн даатгал	1,330,901.00	1,241,494.83
210205	Эрүүл мэндийн даатгал	13,308,905.00	12,414,947.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,858,500.00	18,250,200.00
210301	Гэрэл, цахилгаан	4,686,100.00	5,369,700.00
210302	Түлш, халаалт	9,826,100.00	10,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	346,300.00	2,080,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,151,388.00	9,376,637.00
210401	Бичиг хэрэг	726,600.00	667,600.00
210402	Тээвэр, шатахуун	6,989,988.00	5,687,252.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,626,700.00	1,935,285.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	808,100.00	1,086,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,840,400.00	2,018,212.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	247,700.00	238,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	92,700.00	92,700.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,687,312.50

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	3,284,800.00	992,000.00
210702	Дотоод албан томилолт	3,284,800.00	992,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,796,780.00	5,211,108.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,981,700.00	4,101,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	663,300.00	663,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	217,800.00	217,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,500.00	44,500.00
210807	Газрын төлбөр	169,480.00	183,808.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,786,063.23	80,059,578.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,697,781.23	33,174,289.25
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	315,400.00	302,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,772,882.00	46,582,988.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,969,882.22	25,552,115.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	74,715,100.00	19,941,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	74,715,100.00	19,941,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,254,782.22	5,610,315.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,254,782.22	5,610,315.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	150,553,658.84	26,753,651.81
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	150,553,658.84	26,753,651.81

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	627,273,463.60	43,895,785.58	(257,841,720.50)	413,327,528.68
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	627,273,463.60	43,895,785.58	(257,841,720.50)	413,327,528.68
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	26,753,651.81	26,753,651.81
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	627,273,463.60	43,895,785.58	(231,088,068.69)	440,081,180.49

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	885,865,388.00	840,973,618.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,000.00	100,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	100,000.00	100,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	100,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	885,765,388.00	840,873,618.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	817,820,000.00	823,662,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	816,501,100.00	823,662,000.00

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	1,318,900.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,904,588.00	17,211,618.50
131103	ЗГНХ,ЗДНХХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,524,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		15,089,706.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,904,588.00	597,312.50
1320	Төсвийн захирагчаас	66,040,800.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,040,800.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	885,865,388.00	831,000,164.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	885,865,388.00	831,000,164.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	800,895,505.78	805,448,048.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	676,708,371.78	680,759,610.59
210101	Үндсэн цалин	481,531,023.43	460,812,315.82
210102	Нэмэгдэл	165,232,659.97	196,090,465.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,944,688.38	23,856,829.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,598,166.00	88,196,280.58
210201	Тэтгэврийн даатгал	60,740,937.00	62,865,588.31
210202	Тэтгэмжийн даатгал	6,793,058.00	6,220,408.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,424,365.00	5,453,841.84
210204	Ажилгүйдлийн даатгал	1,330,901.00	1,241,494.83
210205	Эрүүл мэндийн даатгал	13,308,905.00	12,414,947.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,858,500.00	18,250,200.00
210301	Гэрэл, цахилгаан	4,686,100.00	5,369,700.00
210302	Түлш, халаалт	9,826,100.00	10,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	346,300.00	2,080,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,151,388.00	9,376,637.00
210401	Бичиг хэрэг	726,600.00	667,600.00
210402	Тээвэр, шатахуун	6,989,988.00	5,687,252.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,626,700.00	1,935,285.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	808,100.00	1,086,500.00
2105	Нормативт зардал	341,700.00	341,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	341,700.00	341,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,840,400.00	2,018,212.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	247,700.00	238,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	92,700.00	92,700.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,687,312.50
2107	Томилолт, зочны зардал	3,284,800.00	992,000.00
210702	Дотоод албан томилолт	3,284,800.00	992,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,796,780.00	5,211,108.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,981,700.00	4,101,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	663,300.00	663,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	217,800.00	217,800.00

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,500.00	44,500.00
210807	Газрын төлбөр	169,480.00	183,808.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	315,400.00	302,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	315,400.00	302,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,969,882.22	25,552,115.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	74,715,100.00	19,941,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	74,715,100.00	19,941,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,254,782.22	5,610,315.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,254,782.22	5,610,315.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	<u>9,973,454.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		9,973,454.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		9,973,454.00
2200	Дотоод эх үүсвэрээр		9,973,454.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		9,973,454.00
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	<u>(9,973,454.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	823,762,000.00	818,151,684.17	5,610,315.83	99.32
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	823,762,000.00	818,151,684.17	5,610,315.83	99.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	823,762,000.00	818,151,684.17	5,610,315.83	99.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	803,820,200.00	798,209,884.17	5,610,315.83	99.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	682,422,800.00	680,759,610.59	1,663,189.41	99.76
210101	Үндсэн цалин	460,832,600.00	460,812,315.82	20,284.18	100.00
210102	Нэмэгдэл	197,636,000.00	196,090,465.63	1,545,534.37	99.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,954,200.00	23,856,829.14	97,370.86	99.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,127,100.00	88,196,280.58	3,930,819.42	95.73
210201	Тэтгэврийн даатгал	64,830,200.00	62,865,588.31	1,964,611.69	96.97
210202	Тэтгэмжийн даатгал	6,824,200.00	6,220,408.00	603,792.00	91.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,459,400.00	5,453,841.84	5,558.16	99.90

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	1,364,800.00	1,241,494.83	123,305.17	90.97
210205	Эрүүл мэндийн даатгал	13,648,500.00	12,414,947.60	1,233,552.40	90.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,500,200.00	14,500,200.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	5,369,700.00	5,369,700.00	-	100.00
210302	Түлш, халаалт	7,050,000.00	7,050,000.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	2,080,500.00	2,080,500.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,075,900.00	6,075,785.00	115.00	100.00
210401	Бичиг хэрэг	617,600.00	617,600.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	3,346,400.00	3,346,400.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,385,400.00	1,385,285.00	115.00	99.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	726,500.00	726,500.00	-	100.00
2105	Нормативт зардал	341,700.00	341,700.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	341,700.00	341,700.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,830,900.00	1,830,900.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	238,200.00	238,200.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	92,700.00	92,700.00	-	100.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	992,000.00	992,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	992,000.00	992,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,227,300.00	5,211,108.00	16,192.00	99.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,101,700.00	4,101,700.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	663,300.00	663,300.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	217,800.00	217,800.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,500.00	44,500.00	-	100.00
210807	Газрын төлбөр	200,000.00	183,808.00	16,192.00	91.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	302,300.00	302,300.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	302,300.00	302,300.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,941,800.00	19,941,800.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,941,800.00	19,941,800.00	-	100.00

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,941,800.00	19,941,800.00	-	100.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	823,762,000.00	823,762,000.00	-	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	823,662,000.00	823,662,000.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	823,662,000.00	823,662,000.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	100,000.00	100,000.00	-	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	100,000.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	58	58	-	
620001	Удирдах ажилтан	1	1	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	56	56	-	
620003	Үйлчлэх ажилтан	1	1	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,211,618.50	17,211,618.50	-	100.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,211,618.50	17,211,618.50	-	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,211,618.50	17,211,618.50	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,750,000.00	3,750,000.00	-	100.00
210302	Түлш, халаалт	3,750,000.00	3,750,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,300,852.00	3,300,852.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	50,000.00	50,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	2,340,852.00	2,340,852.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	550,000.00	550,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	360,000.00	360,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,160,766.50	10,160,766.50	-	100.00
210604	Урсгал засвар	10,160,766.50	10,160,766.50	-	100.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,211,618.50	17,211,618.50		100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,211,618.50	17,211,618.50	-	100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид	1,524,600.00	1,524,600.00	-	100.00

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	хуваарилсан хөрөнгө				
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,089,706.00	15,089,706.00	-	100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	597,312.50	597,312.50	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	58	58	-	
620001	Удирдах ажилтан	1	1	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	56	56	-	
620003	Үйлчлэх ажилтан	1	1	-	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторовн туслах Э.Алтангэрэл, аудиторовн туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь Аймаг, хотын нутаг дэвсгэрт ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний хэвийн ажиллагаа, нэгжүүдийн зохион байгуулалт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, ус цаг уур байгаль орчны хяналт шинжилгээг зохион байгуулж, төлөв байдлыг үнэлэх, төр, аж ахуйн нэгж байгууллага, ард иргэдийг мэдээллээр хангах үйл ажиллагаа явуулдаг, Байгаль орчин, аялал жуучлалын яамны харьяа байгууллага юм.

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний нэгжүүдийг мэргэжил арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах
- Ус цаг уур байгаль орчны бодит болон ирээдүйн төлөв байдлын тухай мэдээллээр аймгийн төр захиргааны байгууллага, аж ахуй нэгж, иргэдийг хангах
- Ус цаг уур, байгаль орчны зүй тогтол, горимыг тогтоох, судалгаа, шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт гаргах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 19,289.5 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 14,467.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 18,237.5 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 80 хувиар буюу 13,678.2 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 1,051.9 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	1,461.4	0	(1,461.4)
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	49,901.3	38,351.1	(11,550.2)
Үндсэн хөрөнгө	361,964.8	401,730.1	39,765.3
Нийт хөрөнгө	413,327.5	440,081.2	26,753.7
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	413,327.5	440,081.2	26,753.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	413,327.5	440,081.2	26,753.7

Бараа материалын дансны үлдэгдэл 38,351.1 мянган төгрөг болж, 11,550.2 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал Цаг уур орчны шинжилгээний газраас хуваарилагдан ирсэн 21,271.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 33,174.3 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал зарцуулагдсанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 401,730.1 мянган төгрөг болж, 39,765.3 мянган төгрөгөөр өссөн нь Цаг уур орчны шинжилгээний газраас хуваарилагдан ирсэн барилгын их засварын 9,590.5 мянган төгрөгөөр, анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлсэн 66,783.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн 154,945.1 мянган төгрөгийн хөрөнгийг актлан данснаас хассан дүнгээр буурчээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 163,917.2 мянган төгрөгөөр буюу 14.9 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оны мөн үеэс 149,898.6 мянган төгрөгөөр буурсанаас шалтгаалжээ

Нийт зардал өмнөх оноос 40,117.2 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал шилжүүлэг байна. Энэ нь тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн тэтгэмж байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,024,627.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,024,627.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 198,061.0 мянган төгрөгөөр бууруулж, 826,566.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 823,672.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 823,672.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 823,662.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 100.0 мянган төгрөг, нийт 823,762.00 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 823,762.00 мянган төгрөгийг зарцуулж, 5,610.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 17,211.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс бараа үйлчилгээний зардалд 17,211.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Дээд шатны төсвийн захирагчаас нийт 17,211.6 мянган төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд зарцуулсан ба уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал ажиглагдаагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг:

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд

материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 99.1%-тай байна.

3.8 Аудитын гол асуудал

Нийт 1 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 9,973.5 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь 2021 онд нийт 889,107.9 мянган төгрөгийн 25 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулахаас 839,245.7 мянган төгрөгийн 14 мэдээллийг ил тод байршуулаагүй, 29,915.3 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,163.7 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд тогтоосон төлбөрийн актыг 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	3,163.7	2	3,163.7	-	-	100.0
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	-	-	-	-	-	-	100.0
Нийт дүн	2	3,163.7	2	3,163.7	-	-	100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 23,788.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10,788.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,036.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 9,973.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

1.1. Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын зардлын дүнд их засварын зардлын 9,973.5 мянган төгрөгийг тайлагнаагүй, үндсэн үйл ажиллагааны зардалд тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 хавсралтын 6.9-д “Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зарлага хэсэгт ,, үндсэн хөрөнгө худалдан авах, олж бэлтгэхэд болон капиталжих их засварт зарцуулсан мөнгөн зардлыг харуулна” заалт, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “тодруулга ба толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Их засварын зардлын 9,973.5 мянган төгрөгөөр мөнгөн гүйлгээний тайлангийн үндсэн үйл ажиллагааны зардлыг бууруулж, хөрөнгө оруулалтын зардлын дүнг нэмэгдүүлэн залруулсан.

1.2. Үнэ төлбөргүй шилжин ирсэн 869.5 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 54.4 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үндсэн хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хассан үлдэгдэл өртгийн буюу 815.1 мянган төгрөгийн бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 1 дүгээр хавсралт Үндсэн хөрөнгийн бүртгэл хэсгийн 4.33-д “Бэлэг, хандивын хөрөнгийг бүртгэхдээ хөрөнгийн зах зээлийн /авсан өдрийн бодит үнэ/ үнийг ашигладаг. ,, , УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө-ийн параграф 27-д “Хөрөнгийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд түүний өртгийг тэрхүү олж эзэмшилтийн өдрөөрх бодит үнэ цэнээр нь хэмжинэ”, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “тодруулга ба толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үнэ төлбөргүй шилжин ирсэн 869.5 мянган төгрөгийн анхны өртөг болон 54.4 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг

бууруулан, үндсэн хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хассан үлдэгдэл өртгийн буюу 815.1 мянган төгрөгийн бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрч бүртгэн залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Хөдөлмөрийн чадвар алдалтын акттай 4 хүний цалингаас ХХОАТ-ыг чөлөөлөөгүй тооцсоноос ХХОАТ-ын 2,899.9 мянган төгрөгийг цалингаас илүү, хөдөлмөрийн чадвар алдалтын акттай 1 ажилтны 8-12 сарын цалингаас НДШ-ийг 11.5 хувиар тооцсоноос НДШ-ийн 106.9 мянган төгрөгийг илүү суутгасан. Тэтгэвэрт гарсан 1 ажилтны цалингаас ХХОАТ тооцоогүйгээс ХХОАТ-ын 29.9 мянган төгрөгийг цалингаас дутуу суутгасан. Нийт 3,036.7 мянган төгрөгийн алдаа зөрчилтэй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д “Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, 25 дугаар зүйлийн 25.3-т “Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 41 дүгээр зүйлийн 41.2-т “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Нийт 1 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 9,973.5 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалт, “ үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст нийт 889,107.9 мянган төгрөгийн 25 мэдээллийг ил тод байршуулахаас 839,245.8 мянган төгрөгийн 14 мэдээллийг ил тод байршуулаагүй, 29,915.3 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын дүнд капиталжуулсан их засварын хөрөнгийн дүнг тайлагнаагүй.	1	9,973.5	1	9,973.5	-	-			-	-
2	Үнэ төлбөргүй шилжин ирсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгээгүй	1	815.2	1	815.2	-	-			-	-
3	Цалинг буруу тооцоолон олгосон	1	3,036.7			1	3,036.7				
4	Худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй	1	9,973.5					1	9,973.5		
Дүн		4	23,788.9	2	10,788.7	1	3,036.7	1	9,973.5	-	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	869,161.1	-	-	-	-	-	-	1	869,161.1
Дүн		1	869,161.1	-	-	-	-	-	-	1	869,161.1
Нийт дүн		6	892,960.0	2	10,788.7	1	3,036.7	1	9,973.5	1	869,161.1